

АХМАДЫН ТАЛААРХ ИХ МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН БОДЛОГЫН ЗАРИМ АСУУДАЛ

*З.Баасанжав
Түүхийн ухааны доктор (Ph.D)*

Ахмад настан нь нийгмийн нэгэн онцлогтой бүлэг билээ. Тэд улс нийгэмдээ өөрийн гэсэн хувь нэмрээ оруулж, үүргээ гүйцэтгэн улиран өнгөрөх цагийн эрхээр залуу зандан цагийнхаа эрч хүчийг алдсан боловч хуримтлуулсан туршлага, амьдралын арга ухаан, мэдлэг чадвараараа залуу хойч үеийнхэндээ үлгэр дууриалал болж байдагт энэхүү онцлог орших авай.

Ахмад настны нийгмийн эл онцлог нь төрөөс тэдний талаар басхүү ялгавартай агаад нийгмийн халамжийн өвөрмөц бодлого баримтлахыг түүхийн аль ч үед шаардаж ирсэн агаад түүнийг анхааран хэрэгжүүлж ирснийг буурал түүхийн шарласан хуудас гэрчлэх авай.

Овог, түүний үзэл санаа монголын нийгэмд төрж тэрлэн, хөгжиж байсан тэр үед ахмад настан нь овгийн дотор онцгой эрх дархыг эдлэн бас ч багагүй үүрэг хүлээдэг байсан байна. Эртний монголын нийгэмд эцгийн эрхт ёсны овгууд нэгдмэл байсан нь овог бүр нийтийн нэгэн овгоос уг гаралтай гэж үздэгтэй холбоотой. Эндээс ахмадыг хүндэтгэх ёс улбаатай хэмээн хэлж болох талтай.

Харин XIII зууны үе болж ирэхэд энэхүү уламжлал тасраагүй төдийгүй улам баяжин хөгжиж, шинэ агуулгатай болсон байна. Өгүүлэн буй үед хэдэн наснаас дээших хүмүүсийг ахмад настанд багтаан үзэж байсныг яг таг оноон хэлэхэд басхүү судалгаа шаардаж байна. Гэхдээ бидний хойно өгүүлсэн баримтанд 60 наснаас дээших хүмүүст төрийн хишиг хүртээх, түүний дотор 80 наснаас дээших хүмүүсийг онцлон үзсэн нь үүнийг багцаалан гаргах боломж олгож байна. Энэ нь Дэлхийн эрүүлийг хамгаалах байгууллага (ВОЗ)-ын ангилалаар 60 – 74 настанг хижээл, 75-89 настайг өндөр, 90-ээс дээш настанг өтөл хэмээн үзсэн байдагтай¹ ойролцоо байгаа нь сонирхол татаж байна.

Дашрамд нь өгүүлэхэд Монгол улсын засгийн газрын санхүүгийн зөвлөхөөр ажиллаж байсан С.А.Козин, түүний туслах П.А.Витте нарын 1915 онд хийсэн судалгаагаар 0-16, 17-65, 66 -гаас дээш хэмээн ангилж, нийт хүн амын 6.9 хувь нь 65-аас дээш насны хүн байна гэсэн тооцоог гаргасан байна².

Их Монгол улсын үеийн төрийн нийгмийн бодлогод ахмад настны асуудал багагүй анхаарал татаж байсан нь тухайн үеийн түүхийн сурвалж бичгүүдээс тодорхой харагддаг.

Эзэн богд Чингис хааны баримталж байсан ахмад настны талаарх бодлогын тухай товч өгүүлэхдээ дараах үндсэн хэдэн санааг гарган илэрхийлэхийг оролдлоо.

Нэгэн зүйл. Ахмад настан, азай буурлуудын үгийг анхааран “буурлаас үг сонс” гэсэн нэгэн санааг өвөрлөн түүнийгээ ажил амьдралдаа мөрдлөг болгон ирсэн байдаг. Энэ нь тэдний амьдралын ээдрээ нугачааг биеэрээ туулан, хатуу хүтүү, зовлон жаргалын аль алиныг нь үзэж, “туршин” амьдралаар шалгагдсан үнэнд ойртсныг монгол зон олон эрхэмлэн байдгийн илрэл болой.

Ийм ч учраас төрийг удирдах хэрэгт ахмад настанг оролцуулах уламжлалыг манай өвөг дээдэс монгол нутагт төр улс анх үүссэн тэр цаг үеэс л эхлэн бий болгосон байна. Дорно дахиныг судлаач нэрт эрдэмтэн Л.Н.Гумилев Хүннүгийн үед түүний бүрэлдэхүүнд багтаж байсан аймгуудад аймгийн толгойлогч нарт зөвлөх эрхтэй ахмадын зөвлөл байсан тухай өгүүлсэн нь бий. Энэ нь хожмын монгол угсааны улсуудаар уламжлагдан Их монгол улсын үед хүрч иржээ.

Нүүдэлчин монголчуудын мал аж ахуйн хөдөлмөр зохион байгуулалтын үндсэн хэлбэр болсон хот айлыг ахмад настан толгойлон, өөрийн заавар зөвлөлгөөнөөр удирдан чиглүүлж ирсэн уламжлал манайд байсныг энд дурьдахад илүүдэх юун.

Ийн өгүүлэн буйн учрыг бидний хойно иш татсан цөөн хэдэн баримт гэрчлэх авай.

1 Колосов.А.В. Альтшульер Е.А Наука о долголетии. М., 1974, с 14.

2 Ж.Урангуа. XX зууны эхэн Үеийн Монгол улс /1911-1919/, УБ., 2006, 184 дэх талаас дам авлаа.

Чингис хаан хөвгүүдтэйгээ хаан ширээ залгамжлах тухай ярихдаа Зүчид хандан “Чи миний хөвгүүдийн ахмад нь билээ. Юу гэж хэлэх вэ?” гэж, эхлэн ууган хөвгүүнийхээ саналыг сонссон байдаг.

Эзэн богд Чингис хаан “Ахмад хүн дээр очиж буй хэн ч ахмад хүнээс урьд дуугарч, асуухаас өмнө юу ч хэлэх учиргүй. Тэр асуусны дагуу зохих хариуг нь хэл²” хэмээн сургаж байсан гэж Рашид Ад Дин тэмдэглэн үлдээжээ. Тэрчлэн үүнтэй утга нэгэн буюу Чингис хаан дөрвөн хөвгүүндээ хандаж хэлсэн нэгэн удаагийн үгэндээ “Хөвгүүд та нар минь өчигдрийн багмураа дэлгэгтүн. Би урьд тусад сууж, өтгөс ихэс үгээ улсын үйл өгүүлэлдсүгэй хэмээв³

Дээр өгүүлсэн цөөн хэдэн баримтыг иш үндэс болговоос бидний өмнө өгүүлсэн санаа тод болох бүлгээ.

Зөвхөн тэдний үгийг сонсох төдийгүй ахмад настан эцэг өвгөдийн сургаал, гэрээст чин үнэнч байж, түүнийгээ хэрэгжүүлэхийн төлөө хүчин зүтгэх уламжлал нэгэнтээ тогтсон байлаа. Үүнтэй хобогдуулан Чингис хааны отгон хүү Толуйн эцгийн гэрээсийг сахин биелүүлсэн нэгэн баримтыг дурьдсу.

Чингис хаан таалал төгсөх мөчид дэргэд нь байсан Өгэдэй, Толуй нарт “Миний бие мөнх тэнгэрийн хүчинд та нарт аугаа их гүрнийг байгуулж өглөө. Манай монгол нутгаас түүний хил хязгаар хүртэл явахад нэгэн бүтэн жил орно. Ийм өргөн нутаг дэвсгэрийг эзэмшин явахад та нар дуугарвал дуу нэг, дугтарвал хүч нэгтэй байх хэрэгтэй. Тэгвэл сая дайснаа дарж, дархан цолоо мандуулна. Энэ их үүргийг Өгэдэйгээс өөр хүн биелүүлж үл чадмуй. Намайг нас нөгчсөний дараа Өгэдэйг хаан өргөмжлөн та бүгдээр түүний үгийг сонсож яв. Миний зарлигийг битгий зөрчигтүн⁴” хэмээн гэрээслэсэн байдаг. Үүнийг Толуй хичээн сонсож, “Би хаан эцгийн нэрлэсэн ахын дэргэд байж, мартсаныг сануулж, унтсаныг сэрүүлж, уриалах дуунд уухай болж, унах моринд ташуур болж, холын аянд явалцаж, ойрын дайнд оролцож туслая¹” хэмээсэн агаад эл андгайдаа үнэнч байжээ.

Тэрбээр монголын эртний заншлаар хоёр жил төр бариад ах Өгэдэйг дэмжин эцгийн гэрээсийг биелүүлж, Их Монгол улсын хааны сууринд зулайг нь гишгэн төрсөн ахаа өргөмжлөхөд гол үүрэг гүйцэтгэсэн төдийгүй амь насаа золисон тухай Монголын нууц товчооны мэдээ байна.

Алтан улсын байлдаанаас нутаг буцах үеэр Өгэдэй хааныг хүндээр өвчлөхөд бөө төлөгчин нар Алтан улсын газар усны эздийн адлал гэж айлтгаж, хааны ойр төрлийн хүнээр золио өргөж түүний амийг аврах боломжтой хэмээжээ. Үүнийг мэдсэн Толуй “...Үнэхээр хаан ах муужирвал олон монгол улс өнчирч, Хятад улс баясах болно. Хаан ахын оронд би золио больё. Тул загасны нурууг тунтарч явлаа би. Хилэм загасны нурууг хяргаж явлаа би. Илийг ялж, далдыг дарж байв. Миний нүүр гуа, нуруу өндөр биз. Бөө нөр бөөлж залбирагтун²” гээд бөө нарын бөөлөн залбирч, адисласан усыг ууж, таалал төгсчээ.

Нэгэн зүйл. Ахмад настан хүмүүсийг нийгэмд эзлэх байр суурийг нь тодорхой болгож, зарим тохиолдолд “онголох” явдал байсан нь тэдний талаар төрөөс явуулж байсан бодлогын нэгэн онцлог хэмээн хэлж болно.

Эзэн богд Чингис хаан Баарин овгийн хамгийн ахмад Үсүн өвгөнд “...Үсүн, Гунан, Хөхөчос, Дэгэй эд дөрөв үзсэнээ сонссоноо үл нуун хавчин заан байх бүлгээ. Ухсан сэтгэснээ хэлэн байх бүлгээ. Монголын төр ноён мөр, Бэхи болох ажгуу. Баарин ахын ураг билээ. Бэхи мөр... дээрээс Бэхи үсүн өвгөнд болтугай. Бэхи өргөгдөөд цагаан дээл өмсөж, цагаан агт унуулж, суурь дээр суулгаж, бас он сар саатаж, тийн атугай⁴” хэмээн зарлиг болгов гэсэн байдаг.

Бодончараас гаралтай овгуудын дотор баарин овог бол ахмад нь юм. Тухайн үед боржигон овгийнхны дотор хамгийн ахмад нь чухамхүү Үсүн өвгөн байсан нь ийм хүндэтгэлийг хүлээх болсон байна. Мөн Рашид ад Дин энэ тухай “Чингис хаан морь болон бусад малыг онголдогийн (сэтэрлэх)

2 Рашид Ад Дин Сударын чуулган.

3 Лу Алтан товч. УБ., 1990, 120 дахь тал

4 Д.Оссон. Монголын түүх. Орос орчуулга, тал 213. Ш.Нацагдорж. Хубилай сэцэн. УБ., 1998, 9 дэх талаас дамжуулан авлаа.

1 Ш.Нацагдорж. Хубилай сэцэн. УБ., 1998, 9 дэх тал.

2 Монголын нууц товчоо. 272-р зүйл.

4 Монголын нууц товчоо. Ш.Чоймаа нарын хөрвүүлэг. УБ., 2006. 216-р зүйл

нэгэн адил Баарин овгийн хэн нэгнийг онголон чөлөөтэй болгосон гэлцэх юм. Энэ нь түүнийг хэн ч харъяат (албат)-аа болгох эрхгүй. Тэр бол дархан чөлөөтэй байна. Энэ хүний нэрийг Бэхи гэнэ. Ордонд бол тэр бүгдийн дээр, мөн хан хөвгүүдийн адил баруун гарт сууна. Морь нь Чингис хааны морьтой хамт нэгэн уяанд байна. Тэр их л өтөлсөн байлаа” гэсэн нь Монгол нууц товчооны мэдээтэй дүйж байна. Харин энд нэгэн зүйлийг өгүүлэхэд Рашид Ад Дин “бэхи” гэдгийг тухайлсан хүний нэр хэмээн ойлгож ташаарсан байна.

Үүнийг оросын нэрт судлаач Б.Я.Владимирцов зөв онож тайлсан байна. Тэрбээр “Бэхи гэдэг хүн чинь хэн байв аа. Ийм нэр түүхийн сурвалжуудад янз бүрийн овог үеийнхний хувь хүний нэртэй холбоотойгоор тохиолдох нь олонтоо билээ. Гэхдээ ихэнхдээ ууган хөвгүүд ийм зэрэг дэвтэй байдгийг ажиглаж болох юм” гэжээ.

Монголын нууц товчоонд гарч байгаа хүний нэрсэд бэхи хэмээн нэрлэгдсэн нэр 15 орчим байгаагийн 7 нь эмэгтэй хүнийг нэрлэсэн байна. үүнээс үзвэл ууган хөвгүүд ийм зэрэг дэвтэйн зэрэгцээ олны дунд нэр хүндтэй, алдартай, аймаг улсуудын хооронд эв энхийг сахиулах үүрэг хүлээсэн охид хатад ийм алдрыг хүлээдэг байсан бололтой.

Өвөр монголын эрдэмтэн Сайшаалт “Толуй ахас захасаа машид хайрлан хүндэтгэнэ¹” гэж онож хэлсэн байдаг нь ганц түүнд биш тухайн үеийн монголчуудад хамаатай гэж үзэж болно.

Чингис хаан өөрийн ууган хүү Зүчийг доромжилсон удаах хүү Цагаадайг зэмлэн “Зүчийг тэгж хэлж яахан болох вэ?. Хөвгүүдийн минь ахмад нь Зүчи биш үү. Хожим тэгэж бүү хэлтүгэй” гэсэн байдаг нь ах зах хүмүүсийн хүндэтгэх монгол уламжлалыг харуулсан нэгэн баримт болой.

Өөр нэгэн баримт байна. Монголын нууц товчооны мэдээгээр Бат Өгэдэй хаанд, “Мөнх тэнгэрийн хүчинд хаан ахын сууд Мэгэд хотыг эвдэж, Орос улсыг эзэлж, зүг зүгт арван нэгэн харь улсыг оруулж, алтан жолоогоо татаж салалцах болоход их асар босгож, хуримыг хуримлав. Энэ хуриман дээр би бүх хан хөвүүдийн ахмад тул нэг хоёр сархад тэргүүлэн ув. Гэтэл Бүри, Гүюг хоёр надад муудаж хуримнаас гарч одлоо. Явахдаа Бүрийн хэлсэн нь “Бат бид адил байтал яагаад тэргүүлэн уух билээ. Тэр сацуурхах санаатай сахалт эмгэнийг өсгийгээр давтаж, өлмийгээр гишгэчих юмсан” гэжээ. Гүюгийн хэлсэн нь “Бид хоёр тэр нум сум агссан эхнэрийн эгэмийг бороохойгоор зодох юмсан” гэжээ. Бид харь элэгтэй дайсан улсын дотор явж байгаа учир зүйгээ гаргаж хэлсэн боловч Бүри, Гүюг хоёр тэгж хэрүүлийн үгийг хэлээд найрамдалгүй тарав. Одоо яахыг хаан авга мэдтүгэй?” гэжээ

Үүний хариуд Өгэдэй хаан маш их хилэгнэж, “Энэ түрэмгий гайхал хэний үгэнд орж ах хүнийг ам мэдэн доромжлох болов. Ганц муу өндөг ялзарчээ. Ах хүний өөдөөс эсэргүүцсэн аж³” хэмээн машид зэмлэсэн байна.

Нэгэн зүйл. Ахмад настанд төрийн гавъяа шагнал, хүндэтгэл хүлээлгэн хишиг халамж хүртээдэг уламжлал тогтжээ.

“Хөх судар”-ын мэдээгээр эзэн богд Чингис хаан зарлиг болруун: “Орчлонгийн хооронд хүн төрөлтний хочгүй ойр янаг хэмээгч эцэг эх толгой тэргүүн, ах дүү хэмээгч гар хөл, эм үр хэмээгч дээл хувцад, сайд түшмэл хэмээгч хуяг дуулга зэр зэвсэг мэт буюу. Энэ өдөр би хүний эшийн ёсоор эхлэн ялгасугай: тэргүүнд, хаан эцгийн байдал дүрсийг алтаар бүтээж, Тай Мяо-д тахь. (Их сүм хэмээх хятад үг Ш.Чоймаа) жич миний эх тайхуу нас сүүдэр далан долоод хүрч, сүүдэр маш өндөр болсон тул, их хүүгээс шар алт мянган лан, цагаан мөнгө түмэн лан, зотон бөс арван түмэн хэсэг, ... миний харъяат улсын жаран наснаас дээшихэд дан хувь¹, далан наснаас дээшихэд давхар хувь, наян наснаас дээшихэд гурван хувь, ерэн наснаас дээшид дөрвөн хувь, зуун наснаас дээшид таван хувь, зуун арван наснаас дээшийг надад бараалхуул өвөрмөц шагнамуу. Зуун хорин наснаас дээшийг олмогц урьд улсын Го лао цол өргөж, таяг тулуулан надад бараалхуул, өөр өргөмжлөл буй.

1 Сайшаалт. Чингис хааны товчоон, Хөх хот, 1987, 1156 дахь тал.

2 Монголын нууц товчоо. 275 дугаар зүйл.

3 Мөн тэнд. 276 дугаар зүйл.

1 Нэг хувьд нэг лан мөнгө, нэг толгой бөс, арван суулга амууг хэмжээ болгож байв.

Хэрэв үүнээс давагсад аваас цөм сүйхэд суулган дамнан ирж бараалхуул, ангид ялгал буй²” хэмээсэн байдаг.

Монгол төрийн энэхүү жишиг хожим уламжлагдан хэрэглэгдсээр байна. Богд Жибзундамба Монгол улсын хаанаар өргөмжлөгдөөд Олноо өргөгдсөний 2 дугаар оны 1 дүгээр сарын 21 –нд буулгасан нэгэн зарлигтаа “...Далан наснаас дээш наян нас хүртлэх хөгшдөд мөнгө 3 лан, наян наснаас дээших зуун насанд хүрэгсдэд 9 лан, нэг зуун насанд хүрснийг мэдүүлэн ирүүлээд жич өршөөн шагнахыг үзүүлтүгэй³” гэсэн байна. Орчин үед ч манай төр засгийн тэргүүн нар жил бүрийн цагаан сараар улсынхаа өндөр настанд очин золгож, төрийн хүндэтгэл үзүүлдэг уламжлал хэвээр байна.

Энэ дашрамд дээр өгүүлсэн хоёр баримтанд анхаарал хандуулах нэгэн зүйл байгааг өгүүлсү. XIII зууны эхэн үед Чингис хааны гаргасан зарлигт “...Зуун хорин наснаас дээшхийг олмогц” гэж ихэд онцгойлон үзсэн байхад XX зууны эхэн үед гарсан Богдын зарлигт “...нэгэн зуун насанд хүрснийг мэдүүлэн” гэсэн нь тухайн үеийн ахмад настны насны талаар нэгэн сэжмийг мэдээлж байна. Магадгүй XX зууны эхэн үе гэхэд монголчуудын насны дээд хязгаар өмнөх үеийнхээс буурсан байж болох талтай. Гэвч энэ талын судалгаа шаардлагатай юм.

Дээр өгүүлснийг хураангуйлваас Их Монгол улсын төрийн нийгмийн бодлогод ахмад настны тухай асуудал чухал байр суурь эзэлж ирсэн агаад тэднийг эрхэмлэн хүндэтгэж, төрийн хишиг ивээлд багтаахын сацуу хуримтлуулсан мэдлэг туршлагаас нь суралцах, түүнийг хойч үедээ уламжлуулан үлдээх зэрэг чиглэлээр онцгой анхаарал тавьж байсныг буурал түүхийн хуудас гэрчлэх авай.

Энэ нь дараа дараагийн үеүдэд уламжлагдан монгол төрийн нийгмийн бодлогын нэг гол зангилаа асуудал болжээ.

Ашигласан материал

1. Лувсанданзан. Алтан товч. УБ., 1990.
2. Монголын нууц товчоо. Ш.Чоймаа нарын хөрвүүлэг, УБ., 2006
3. Монголын ард түмний 1911 оны эрх чөлөө, тусгаар тогтнолын тэмцэл. Баримт бичгийн эмхтгэл. (1900-1914), УБ., 1982
4. Рашид Ад дин. Судрын чуулган, Ц.Сүрэнхорлоогийн орчуулга, УБ., 2003.
5. Владимирцов.Б.Я. Общественной строй Монголов. Монгольской кочевой феодализм. Л, 1934
6. В.Инжаннаши. Хөх судар. Гутгаар дэвтэр. (Ш.Чоймаа нарын хөрвүүлэг) УБ., 2005
7. Ш.Нацагдорж. Хубилай сэцэн, УБ., 1998

2 В.Инжаннаши. Хөх судар. Гутгаар дэвтэр. УБ.,2005, 82-83 дахь тал.

3 Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын тэмцэл. Баримт бичгийн эмхтгэл. (1900-1914), УБ., 1982, 126 дахь тал.